

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГЭР ХОРООЛЛЫН АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖИЙГ САЙЖРУУЛАХ
ЗАМААР ХӨРСНИЙ БОХИРДЛЫГ
БУУРУУЛАХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Ж.ЧОЙХАНД ТАНАА

2020.04.30 № 06/1447
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

9006109
9019120396

Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Ж.Чойханд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын үр дүнд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, аргачлалд нийцсэн санхүүгийн программ хангамж ашиглан нягтлан бодох бүртгэл хөтөлж ажиллах болон Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх талаар зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 03-наас 2020 оны 04 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ц.Ганболд, аудиторын туслах Н.Энхцэцэг нар хэрэгжүүлэв.

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Далайван Аудит ХХК нь 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр төслийн нэгжийн санхүүгийн тайланг хүлээн авч аудитын ажлыг эхлүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн Газар, АХБ хооронд 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн гэрээгээр “Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл”-ийг хэрэгжүүлэхэд АХБ-аар дамжуулан “Ядуурлыг бууруулах Японы сан”-гаас санхүүжигдэх 2,800,000 ам.долларын МОН-9189 буцалтгүй тусламжийг олгохоор болсон. Буцалтгүй тусламжийн гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болсон. Буцалтгүй тусламжийн дуусах хугацаа нь 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байна.

Төслийн зорилго нь: Төслийн үр дүнд гэр хорооллын бүсэд сайжруулсан ариун цэврийн байгууламжийг барьж, туршин тогтвортой байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэн, төлөвлөлтийг боловсронгуй болгосноор нийгмийн эрүүл мэндийн нөхцөлийг сайжруулан, хөрсний бохирдлыг бууруулна.

Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүргийн 6-р хороо, 7-р хороо, 40-р хороо болон Баянзүрх дүүргийн 27-р хороодод 510 ширхэг нэвчилтгүй суурийн нүхтэй сайжруулсан ариун цэврийн байгууламж, 900 ширхэг экологид ээлтэй ариун цэврийн байгууламж (Экосан)-ийг бариж суурилуулан айл өрхүүдэд хүлээлгэн өгсөн байна. Мөн сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилтын хүрээнд бордоо боловсруулах цэгийг байгуулахаар газрын зөвшөөрлийг авч ажлыг эхлүүлсэн байна.

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл нь 2018 онд санхүүгийн тайлангаа БОАЖЯ-нд өгч улсын төсөвт нэгтгүүлсэн.

Улсын Их Хурлаас Монгол Улсын 2019 оны жилийн төсвийг боловсруулахдаа Засгийн газрын шугамаар хэрэгжиж байгаа зээл, тусламжийн бүх төсөл хөтөлбөрүүдийг Сангийн сайдын багцад шилжүүлэн баталсан. Үүнтэй холбоотойгоор төсөл нь 2018 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон хаалтын тайлангаа БОАЖЯ-нд өгч Сангийн яаманд балансын тэг үлдэгдэлтэй шилжсэн. Ингэхдээ эхний үлдэгдэлгүй шилжүүлэлт хийсэн байна.

Бид аудитын тайланг бэлтгэхдээ өмнөх аудитлагдсан эхний үлдэгдлийг 2019 оны санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй зэрэгцүүлсэн.

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”
- Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төслийн нэгж нь өөрийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан дагаж мөрддөг.

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Гүүксофт” ХХК-ийн “Axplorer” программ хангамж ашиглаж байна.

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Төсөл нь төлөвлөсөн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх, буцалтгүй тусламжийн хөрөнгийг зорилгын хүрээнд үр ашигтай зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, ил тод байдлыг хангахын тулд төслийн гүйцэтгэлийн хяналт, санхүүгийн хяналт, худалдан авах үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэг. АХБ болон Төслийн гүйцэтгэгч байгууллагаас төслийн үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж ажилладаг.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Нийт зардлын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсөл хэрэгжүүлэх нэгж нь АХБ-ны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр орлогын эх үүсвэрийг бүрдүүлдэг тул нийт зардлаас тооцох нь илүү оновчтой гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,581,935.7 мянган төгрөгөөс 71,638.7 мянган төгрөгөөр тооцон материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 449,838.6 мянган төгрөгөөр буюу 148.31 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Мөнгөн хөрөнгө, Урьдчилж гарсан зардал, Хуримтлагдсан үр дүн дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,900.2	395,788.4	393,888.2
Урьдчилж гарсан зардал	237,484.7	314,102.3	76,617.6
Бараа материал	1,542.4	1,542.4	-
Үндсэн хөрөнгө	75,112.5	75,112.5	-
Хуримтлагдсан элэгдэл	(20,231.9)	(37,399.1)	(17,167.2)
Биет бус хөрөнгө	12,000.0	12,000.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(4,500.0)	(8,000.0)	(3,500.0)
Нийт хөрөнгө	303,307.9	753,146.5	449,838.6
Хуримтлагдсан үр дүн	303,307.9	753,146.5	449,838.6
Өмнөх оны үр дүн	371,917.2	303,307.9	(68,609.3)
Тайлант оны үр дүн	-68,609.3	449,838.6	518,447.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	303,307.9	753,146.5	449,838.6

Мөнгөн хөрөнгө: Төсөл нь тайлант хугацааны эцэст ам.долларын дансны үлдэгдэл 393,206.8 мянган төгрөг, төгрөгийн дансдын нийт үлдэгдэл 2,581.6 мянган төгрөг байна.

Урьдчилж гарсан зардал: Тайлант хугацаанд сайжруулсан ариун цэврийн байгууламжийг барьж байгуулах ажлын урьдчилгаа төлбөр 205,205.0 мянган төгрөг, төслийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, хөрсний чанарын хяналт хийх, ариун цэврийн байгууламжийн мониторингийн зөвлөх үйлчилгээний урьдчилгаа төлбөр 108,897.3 мянган төгрөг тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө: АХБ-ны санхүүжилтээр төслийн нэгжийн үйл ажиллагаанд зориулан худалдан авсан компьютер, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөөр, санхүүгийн програм хангамжийг биет бус хөрөнгөөр тус тус бүртгэсэн. Тайлант хугацаанд

үндсэн хөрөнгөнд 17,167.2 мянган төгрөгийн, биет бус хөрөнгөнд 3,500.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардлаар бүртгэсэн.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхэд зориулан тайлант онд 3,642,062.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 3,997,616.1 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан.

Хүснэгт 2. Төслийн орлого

/мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	3,642,062.1	3,997,616.1	(355,554.0)	109.76
Нийт дүн	3,642,062.1	3,997,616.1	(355,554.0)	109.76

Төсвийн зардлын гүйцэтгэл 3,634,736.1 мянган төгрөг буюу 99.80 хувьтай буюу төслийн үйл ажиллагааны зардал 7,326.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 3. Төслийн зардал

/мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт зардал ба цэвэр зээлийн дүн	3,642,062.1	3,634,736.1	7,326.0	99.80
Нийт дүн	3,642,062.1	3,634,736.1	7,326.0	99.80

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан төсвийн хүрээнд зүй зохистой зарцуулсан.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар 2 алдаа, зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч Менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дор дурдсан асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Төсвийн тухай хуульд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байхаар зааснаар нягтлан бодох бүртгэлээ УСНББОУС-ын дагуу бүрэн аккруэл суурь ашиглан бүртгэх шаардлагатай болсон. Иймд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдсэн заавар, аргачлалыг Сангийн яамнаас тусгайлан гаргах хэрэгтэй байна. Уг заавар, аргачлалд төслийн нэгж нь АХБ-ны зарцуулалтын үндсэн процедур болох шууд төлбөр, урьдчилгаа төлбөр, нөхөн дүүргэлтийг аккруэл сууриар хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэж тайлагнах,

хүлээн авсан болон зарцуулсан санхүүжилтэнд гадаад валютын ханшийг хэрхэн ашиглах, төслийн санхүүжилтээр бий болсон биет болон биет бус хөрөнгийн элэгдүүлэх хугацаа болон арга, төслийн санхүүжилтээр хийгдэж байгаа барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг хэрхэн хуримтлуулан бүртгэх, хөрөнгийг төсөл дуусахад төрийн өмчид шилжүүлэх, зээл тусламжийг төслийн нягтлан бодох бүртгэлд өр төлбөрөөр тусгах эсэх, зээлийн хүүгийн өр төлбөрийг хэрхэн бүртгэх;

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд шаардсан мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг хянах;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө болон төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг эдийн засгийн ангиллаар нь задалж тайлагнаж байгаа эсэхийг хянах;

2.12. Шилэн дансны мэдээлэл

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 107 мэдээлэл байршуулахаас 101 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 21,397.0 мянган төгрөгийн зөрчилд хүргүүлсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн программ хангамжийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Гүүксофт” ХХК-ийн “Axplorer” санхүүгийн программ хангамж ашигладаг. Тайлант хугацаанд програмд сайжруулалт хийгдсэн боловч хангалтгүй байна.

Тус программ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, УСНББОУС-д нийцээгүй, харин АХБ-ны Зарцуулалтын журмын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төслийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал алдаатай бэлтгэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төслийн санхүүгийн программыг Нягтлан бодох бүртгэлийн хууль, УСНББОУС-ын шаардлагад нийцүүлсэн байдлаар шинэчлэх, холбогдох өөрчлөлтийг оруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Уг санхүүгийн програмыг АХБ-ны Зарцуулалтын журмын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр анх даалгавар боловсруулж хийгдсэн бөгөөд 2019 онд өөрчлөлт, сайжруулалт хийгдсэн. Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Шилэн дансны мэдээллийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 107 мэдээллийг байршуулахаас 101 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хууль зөрчих, мэдээлэл буруу орох.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг тогтсон хугацаанд нь бүрэн гүйцэд оруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	240,927,339.46	711,433,119.32
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,900,233.05	395,788,437.91
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,900,233.05	395,788,437.91
31210	Төгрөг	0.00	395,788,437.91
31211	Төрийн сангийн харилцах	0.00	2,581,617.93
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	393,206,819.98
31220	Гадаад валют	1,900,233.05	0.00
31223	Арилжааны банк дахь харилцах	1,900,233.05	0.00
34	УРЬДЧИЛГАА	237,484,708.41	314,102,283.41
34600	Урьдчилж гарсан зардал	237,484,708.41	314,102,283.41
35	БАРАА МАТЕРИАЛ	1,542,398.00	1,542,398.00
35400	Хангамжийн материал	1,542,398.00	1,542,398.00
35420	Аж ахуйн материал	0.00	685,798.00
35470	Бусад хангамжийн материал	1,542,398.00	856,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	62,380,579.12	41,713,429.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	62,380,579.12	41,713,429.12
39200	Биет хөрөнгө	54,880,579.12	37,713,429.12
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	53,286,000.00	53,286,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,776,058.38)	(31,760,558.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,826,500.00	21,826,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,455,862.50)	(5,638,512.50)
39300	Биет бус хөрөнгө	7,500,000.00	4,000,000.00
39301	Програм хангамж	12,000,000.00	12,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,500,000.00)	(8,000,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	303,307,918.58	753,146,548.44
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	303,307,918.58	753,146,548.44
51	Засгийн газрын хувь оролцоо	303,307,918.58	753,146,548.44
51200	Хуримтлагдсан үр дүн	303,307,918.58	753,146,548.44
51210	Өмнөх үеийн үр дүн	371,917,195.77	303,307,918.58
51220	Тайлант үеийн үр дүн	(68,609,277.19)	449,838,629.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	303,307,918.58	753,146,548.44

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	899,591,054.02	4,009,944,668.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	899,591,054.02	4,009,944,668.08
120	Нийтлэг татварын бус орлого	899,591,054.02	4,009,944,668.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,195,344.88	4,009,944,668.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,195,344.88	12,328,608.21
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	3,997,616,059.87
122	Тусламжийн орлого	896,395,709.14	0.00
122002	Хандив тусламж /гадаад/	896,395,709.14	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	980,174,264.20	1,151,756,176.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	980,174,264.20	1,151,756,176.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	851,724,264.20	1,151,756,176.64
2104	Хангамж, бараа материалын зардал	6,631,149.74	47,793,940.31
210401	Бичиг хэрэг	6,631,149.74	19,748,752.05
210402	Тээвэр, шатахуун		21,490,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		6,554,788.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	828,353,264.46	1,080,145,086.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	828,353,264.46	1,080,145,086.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,739,850.00	23,817,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	900,000.00	3,150,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,839,850.00	20,667,150.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	128,450,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	128,450,000.00	0.00
222001	Хаагдсан данс	128,450,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(80,583,210.18)	2,858,188,491.44
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	11,973,932.99	21,829,663.42
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	11,973,932.99	21,829,663.42
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	2,430,179,525.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	0.00	2,430,179,525.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(68,609,277.19)	449,838,629.86

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	903,839,114.03	4,011,844,901.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	903,839,114.03	4,011,844,901.13
120	Нийтлэг татварын бус орлого	7,443,404.89	14,228,841.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,443,404.89	14,228,841.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,443,404.89	9,178,608.21
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	0.00	1,900,233.05
120009	Бусад орлого	0.00	3,150,000.00
122	Тусламжийн орлого	896,395,709.14	3,997,616,059.87
122002	Хандив тусламж /гадаад/	896,395,709.14	3,997,616,059.87
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	944,781,697.61	1,131,089,026.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	944,781,697.61	1,131,089,026.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	944,781,697.61	1,131,089,026.64
2104	Хангамж, бараа материалын зардал	6,631,149.74	47,793,940.31
210401	Бичиг хэрэг	596,909.09	19,748,752.05
210402	Тээвэр, шатахуун	5,025,600.00	21,490,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,008,640.65	6,554,788.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	937,250,547.87	1,080,145,086.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	937,250,547.87	1,080,145,086.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	900,000.00	3,150,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	900,000.00	3,150,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(40,942,583.58)	2,880,755,874.49
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	257,037,425.00	2,506,797,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	257,037,425.00	2,506,797,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	257,037,425.00	2,506,797,100.00
222001	Тоног төхөөрөмж	257,037,425.00	2,506,797,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(257,037,425.00)	(2,506,797,100.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	11,973,932.99	21,829,663.42
14	Бусад эх үүсвэр	11,973,932.99	21,829,663.42
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	11,973,932.99	21,829,663.42
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(286,006,075.59)	395,788,437.91
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	287,906,308.64	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,900,233.05	395,788,437.91

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

					/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	
1	2017 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	371,917,195.77	371,917,195.77	
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	371,917,195.77	371,917,195.77	
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00	
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(68,609,277.19)	(68,609,277.19)	
10	2018 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	303,307,918.58	303,307,918.58	
11	2019 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	303,307,918.58	303,307,918.58	
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	303,307,918.58	303,307,918.58	
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00	
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	449,838,629.86	449,838,629.86	
20	2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	753,146,548.44	753,146,548.44	

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,642,062,100.00	3,634,736,126.64	7,325,973.36	99.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,134,800,000.00	1,127,939,026.64	6,860,973.36	99.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,134,800,000.00	1,127,939,026.64	6,860,973.36	99.40
2104	Хангамж, бараа материалын зардал	47,799,100.00	47,793,940.31	5,159.69	99.99
210401	Бичиг хэрэг	18,293,500.00	19,748,752.05	(1,455,252.05)	107.96
210402	Тээвэр, шатахуун	22,948,800.00	21,490,400.00	1,458,400.00	93.64
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,556,800.00	6,554,788.26	2,011.74	99.97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,087,000,900.00	1,080,145,086.33	6,855,813.67	99.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,087,000,900.00	1,080,145,086.33	6,855,813.67	99.37
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,507,262,100.00	2,506,797,100.00	465,000.00	99.98
222001	Тоног төхөөрөмж	2,507,262,100.00	2,506,797,100.00	465,000.00	99.98
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,642,062,100.00	4,006,794,668.08	(364,732,568.08)	110.01
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	9,178,608.21	(9,178,608.21)	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	9,178,608.21	(9,178,608.21)	100.00
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	3,642,062,100.00	3,997,616,059.87	(355,553,959.87)	109.76
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	3,642,062,100.00	3,997,616,059.87	(355,553,959.87)	109.76
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	373,958,774.49		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		8.00		
620001	Удирдах ажилтан		1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан		2.00		
620004	Гэрээт ажилтан		5.00		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.04.27	Аудитын нэр:	<i>Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит</i>	Аудитын код: САГ-2020/728/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл</i>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуулла-гаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Гүүксофт” ХХК-ийн “Axplorer” санхүүгийн программ хангамж ашигладаг. Тайлант хугацаанд програмд сайжруулалт хийгдсэн боловч хангалтгүй байна. Тус программ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, УСНББОУС-д нийцээгүй, харин АХБ-ны Зарцуулалтын журмын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Ж.Чойханд
2	Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 107 мэдээллийг байршуулахаас 101 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Ж.Чойханд
Зөвлөмжийн дүн		-			

